

## "SEVEN NUGA RESORT"

### **Ресторан**

7 нуга ресторан нь 150 хүний хүчин чадалтай бөгөөд Европ, Монгол, Итали, Мексик гэх мэт хоолны өргөн сонголттойгоор Монгол гадаад мэргэжлийн тогооч нартайгаар хоолны соёлыг түгээн дэлгэрүүлж байна.

Вип өрөө нь 10-30 хүн хүлээн авах боломжтой дотроо 90инч ухаалаг зурагт, террасе, хөгжим тоног төхөөрөмж, караоке, бизнес уулзалт, хурал зөвөлгөөн хийхэд тохиромжтой, төрсөн өдөр тэмдэглэлт баярын тансаг зэрэглэлийг ширээ засалтуудаар үйлчилдэг.

Заалны үйлчилгээ нь мэргэжлийн Бартендер урласан нэрийн холимог ундаанууд, Дээд зэрэглэлийн дарснууд гэх мэт олон төрлийн уух зүйлсийн сонголттой цэсээр зөөгч нар санал болгон үйлчилгээний тав тухыг танд мэдрүүлэн үйлчилнэ.

Рестораны террасе нь 150 хүний хүчин чадалтай, цэлгэр харагдахуйц зай талбайтай, Тайз болон сүүлийн үеийн хөгжим, гэрэл тоног төхөөрөмжөөр тоноглогдсон. Зундаа олон төрлийн шоу, хүлээн авалт, арга хэмжээнүүд зохион байгуулдаг.

### **Хүлээн авалтын их танхим**

Хүлээн авалтын их танхим нь 250 хүний хүчин чадалтай бөгөөд орчин үеийн ширээ сандал дотоод тохижилттой, 10м өргөнтэй ЛЭД дэлгэц, тайз, хөгжим, диско гэрэл, утааны машин гэх мэт хүчирхэг тоног төхөөрөмжүүдтэй. Хурим найр, бизнес хурал зөвөлгөөн, байгууллагын ойн арга хэмжээ, хамтлаг дуучдын тоглолт, төрийн өндөр зэрэглэлийн хүлээн авалт, гэх мэт олон төрлийн арга хэмжээг өндөр түвшинд зохион байгуулдаг.

### **Галын наадмын талбай**

Галын наадам нь 30 хүний багтаамжтай тусгайлан засаж тохижуулсан зай талбайд хийгддэг бөгөөд шорлог шарах, халуун дарс шимэх, салют буудуулах, хөгжим, лазер гэрэл гэх мэт олон төрлийн үйлчилгээг авах боломжтой.

### **Усан Бассейн**

Зөвхөн амрагч нарт зориулсан Усан Бассейн нь 3 замтай, 20 метр урттай,

6 метр өргөнтэй, 1.5 метрийн гүнтэй. 14 наснаас доош хүүхэд харгалзах хүнтэйгээр ордог бол бусад насныхан чөлөөтэй үйлчлүүлж болно.

Бассейны гадна террасе дээр өглөө эрт Иог дасгал хөдөлгөөн хийх, наранд биеээ шарах, коктейль шимж хэвтэнгээ байгалийн сайханыг толидож амар амгаланг

мэдрэх, байгууллага хамт олны олон төрлийн арга хэмжээнүүдийг зохион байгуулж болдог.

### **Тоглоомын төв**

Зөвхөн амрагч нарт зориулсан тоглоомын төв нь дотроо Снүүкер, сонирхогчын гэсэн биллиардын 3 ширээтэй. Ширээний теннис, ширээний хөл бөмбөг, PS5 гэх мэт олон төрлийн тоглоомтой учраас амрагч хүүхэд залуучууд, байгууллага хамт олны тэмцээн уралдаан зохион байгуулахад нэн тохиромжтой төв юм.

### **Чийрэгжүүлэх өрөө**

Амрагч, ажилчид нарын эрүүл мэндэд санаа тавих зорилгоор орчин үеийн фитнес өрөөг сүүлийн үеийн тоног төхөөрөмжөөр тоноглож тохижуулан бэлдсэн.

### **Гэрэлт усан оргилуур**

Төв цэгт байрлах 10 метр өндөрт оргилох гэрэлт усан оргилуур нь ая дууны хэмнэлээр удирдагдаж зуны халуун оройг сэрүүцүүлж хүүхэд багачуудын тоглох дуртай хэсэг болж чадсан.

### **Дуплекс байшин**

Ресортын хясааны дэргэд байрладаг харагдах орчин үнэхээр сайхан уг 2 давхар хаус нь 4-6 хүн амрах бөгөөд 2 өргөн, 2 нарийн ортой, дотроо ариун цэврийн өрөө, душ, камин зуух, тв интернет, мини бар гэх мэт 5 одны зэрэглэлээр тоноглогдсон ба 3 төрлийн өглөө цайнаас сонголтоо хийн зооглож байгалийн тэврэлтэнд террасе дээрээ тухлан амрах боломжтой.

### **Делюкс байшин**

Орчин үеийг шийдлээр баригдсан уг 1 давхар байшин нь мөн адил 5 одны зэрэглэлээр тоноглогдсон, 2 өргөн ортой 2-4 хүн амрах боломжтой модтой ойрхон байрладаг онцлогтой, Мөн 3 төрлийн өглөө цайнаас сонгон зооглож модон дунд суун тухлан амрах боломжтой.

### **Цомцог гэр**

Уламжлалт хэв маягын цомцог гэр нь жуулчдын сонирхолыг ихээр татдаг ба дотроо 4 нарийн ортой, шалны халаалт, ариун цэврийн өрөө, душ, мини бар, тв интернет гэх мэтээр тоноглогдсон тав тухтай гэр юм.